

“ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЕВРАЗИЙН БОДЛОГО”*С.Энхцэцэг**

Евразийн үзэл санаа гэдэг цоо шинэ ойлголт биш юм. Түүхэн үүднээс авч үзвэл энэ нь Орос гэдэг том гүрний үе үеийн төр, эрх баригчдын үзэл санаанд тулгуурлан түүхэн үеийн туршид янз бүрийн утга санаа, агуулга хэлбэрээр баяжигдан хөгжсөөр ирсэн оросуудын мах цусанд шингэсэн төрийн бодлогын номлол бөгөөд Евразийн номлол гэж тунхаглан зарладаггүй ч гэсэн Оросын үе үеийн төрийн бодлогын үндэс болсоор ирсэн уламжлалт үзэл санаа юм. Евразийн үзэл санааны үндэс Оросын газар нутаг, шашин, үндсэрхэг үзэлтэй шууд холбоотой. Учир нь ОХУ нутаг дэвсгэрийн хэмжээгээр дэлхийд тэргүүлдэг төдийгүй Европ, Ази тивийг дамнасан, геополитикийн ашигтай байрлалд оршдог төдийгүй энэхүү давуу байдалдаа тулгуурлан гадаад, дотоод бодлогоо тодорхойлдог байна. Өөрөөр хэлбэл, Оросын газар, нутаг дэвсгэр дангаараа Европ, Азийн аль алинд хамрагддаггүй. Харин аль алиных нь шинжийг агуулсан синтезийн үүрэг гүйцэтгэгч евразийн гэж нэрлэгдэх бие даасан онцгой ертөнц гэсэн үзлийг Оросын геополитикийн номлолыг боловсруулагчид, улс төрийн зүтгэлтнүүд баримталж иржээ. Өнөөгийн ОХУ-ын нутаг дэвсгэрийн 70% Азийн хэсэгт, 30% нь Европын хэсэгт оршдог. Энэ нь евразийн үзэл санааны үндэс болж өгчээ. Тиймээс өнөөгийн ОХУ Европ, Азийн бодлогыг явуулахгүй харин өөрийн эрх ашигт нийцсэн, үндэсний уламжлал, соёл иргэншлийн онцлогоо тусгасан геостратегийн бодлого явуулна гэж тунхаглаж байгаа нь түүний бодит илрэл мөн. Мөн Орос цорын ганц үнэн алдартны шашин бүхий загалмайтны уламжлалыг хадгалагч орон болж үлдсэн нь бас евразийн үзэлд тусгагджээ. Энэ нь Оросын бусдаас ялгарах нэгэн өвөрмөц онцлог төдийгүй евразийн үзэл санаа соёл шашны хувьд Византын эзэнт гүрний үеэс улбаатай европ гаралтай гэдгийг нь тодорхойлж байна. Засаглал, цэрэг зэвсгийн хувьд хүчтэй байсан эзэнт улсууд, газар зүйн өвөрмөц тогтоц нь евразийн соёлын өвөрмөц шинжийг бүрдүүлжээ. Оросын оюун санааны туйлын зорилго бол дэлхийн соёлын янз бүрийн өвийн санд өөрийн ертөнцийг ямар ч үнээр хамаагүй авч үлдээд өрнөдийн далайн соёл, дорнийн уламжлалаас өвөрмөц чанараа хамгаалах явдал юм. Эндээс барууны соёл, дорнийн уламжлалтай эн тэнцэх евразийн соёлын ертөнцийг төлөөлсөн гүрэн Орос учир түүний явуулах бодлого ч дэлхийн хэмжээний байх ёстой гэсэн санаа урган гарч ирж байна.

Евразичууд нь Оросын коммунист сурталтнууд, түүнийг баримтлагч Монголын зарим “зүтгэлтэн” Татар - Монголын дарлал,

*С.Энхцэцэг - МУИС-ийн ОУХС-ийн олон улсын эдийн засгийн харилцааны тэнхим, магистр

Чингис түүний дараах хаадын үүрэг ролийг дан хараар будсанаас өөрөөр авч үзжээ. Оросын түүхэн дэх Монгол-татарын дарлалыг зөвтгөжээ. Чухамхүү түүний ачаар л Орос Евразийн их гүрэн болох эхлэл тавигдсан байна. Монголын байлдан дагуулал Оросыг евразийн түүхэн голдирол руу татан оруулж нэгдмэл нэг төрийн дор олон үндэстнүүдийг нэгтгэх гэсэн эртний хүчирхэг монголчуудын үзэл санааг өөрийн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлснээр нөлөөгөө тэлж улмаар ЗХУ гэсэн их гүрнийг байгуулсан явдал нь Оросын геополитикийн хамгийн өрнөл үе байв. Тиймээс дахин ЗХУ-ын дайтай гүрнийг төрүүлэх хүсэл өнөөгийн ОХУ-ын нийгэмд хүчтэй байсаар байна. Евразийн улс төрийн нэгдмэл байдал нь төрийн байгууллын нэгдмэл чанар, газар зүйн хүчин зүйлтэй салшгүй холбоотой. Евразийн нутаг дэвсгэрт мандаж байсан Монголын эзэнт гүрэн, Оросын их гүрэн ялгаагүй аль аль нь засаглалын хамгийн захирангуй бүтэцтэй байв. Энэ нь аргагүй юм. Учир нь евразийн өргөн уудам нутагт орших олон янзын шашин шүтдэг, өөр өөр зан заншил, соёл бүхий ард түмнүүдийг нэгэн төрийн дор нэгтгэхийн тулд эдийн засаг, соёл, цэрэг зэвсгийн хувьд бусдаас давуу байж тэдэнд нөлөөлөх улмаар нэгтгэх бодлого явуулахдаа засаглалын захирангуй хэлбэрийг сонгох болдог байна. Тиймээс түүхэн үеийн туршид евразийн засаглалын үндсэн зарчим нь идеократ байсаар ирсэн гэж хэлбэл нэг их хилсдүүлэхгүй болов уу. Өнөөгийн ОХУ-ын хөгжлийн тогтворгүй байдал ч нэг талаар үүнтэй холбоотой юм. Учир нь угаасаа чанга хатуу захирангуй нийгэмд дасан зохицсон евразийн гүрэнд ардчилсан, либерал нийгмийн тогтолцоог шууд авч хэрэглэх нь тохирохгүй байж болох талтай. Тиймээс ч өнөөгийн ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин “Орос улс үүсэн байгуулагдсан тэр үеэс эхлэн нэгэн төвлөрсөн засаглал бүхий улс байсан бөгөөд энэ байдал Оросын уламжлал, иргэдийн оюун санаанд гүн гүнзгий шингэжээ. Орос хүний хувьд хүчтэй төр тийм ч хэвийн үзэгдэл биш. Харин энэ нь дэг журмын үндэс, баталгаа мөн” гэж тунхаглан зарлаж байгаа нь олонхи оросуудын санаанд туйлын нийцэх болж, улмаар явуулж буй бодлогын үр дүн ч илэрхий ажиглагдаж байна.

ОХУ-д төрийн үзэл баримтлалаа холбож тайлбарласан олон янзын шинэлэг үзэл санаа байгаа ч эдгээр нь учир дутагдалтай ХХI зууны Оросын их гүрний эрх ашигт бүрэн дүүрэн нийцэхгүй байна. Учир нь ирж буй зуунд хэвшмэл хуучирсан онолыг дагаж мөрдөх бус харин асуудалд бодитой хандах прагматик хандлага давамгайлах болсонтой холбоотой. Өөрөөр хэлбэл евразийн үзэл санаа нийгмээ даган өөрчлөгдөж, өнгөрсөн алдаанаасаа суралцах, орчин үеийн ололттой талыг тусгаж цаг үедээ тохирсон уян хатан байх шаардлага гарч ирж байна. Тиймээс ч өнөөгийн евразийн үзэл санаа прагматик

байдлаар тэнцвэртэйгээр аливаа асуудалд хандах нь зүйтэй гэсэн шинэлэг санаа агуулах боллоо. Энэ нь дэлхийн хөгжлийн чиг хандлагатай уялдан түүнд гарч буй зарчмын томоохон өөрчлөлт гэж үзэж болно.

ОХУ төрийн бодлогын үндэс болсон томоохон баримт бичиг болох 1993 онд баталсан гадаад бодлогын үзэл баримтлал, 1997 онд баталсан үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа 2000 онд дахин шинэчлэв. Энэ нь олон улсын харилцааны чиг хандлага, ОХУ-ын гадаад улс төрийн байдалтай холбоотой. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа өнөөгийн олон улсын харилцаанд үнэлэлт дүгнэлт өгч, ашиг сонирхлоо тодорхойлсны зэрэгцээ дотоод, гадаад аюул заналыг тоочиж, үндэсний аюулгүй байдлыг хангах арга замуудыг тодорхойлжээ. Дэлхийд тэргүүлэх, ганц туйлт ертөнцийг буй болгох гэсэн АНУ-ын оролдлого ОХУ-ын стратегийн эрх ашигтай зөрчилдөж, дургүйцлийг нь төрүүлж байна. Өөрийн тэргүүлэх байр сууриа Оросоор хүлээн зөвшөөрүүлэх, өрнөдийн нөлөөллийн хүрээг өргөтгөх бодлоготой эвлэрэхийг шаардаж байна гэж үзээд түүнийг сөргүүлэн ОХУ дэлхийн шинэ дэг журам тогтоохыг уриалав. Энэ нь тэдний дураар авирлах бодлогыг хязгаарлах, статусын хувьд адил хүчний олон төвүүд бий болгох зорилготой.

Мөн улс орнуудын эдийн засаг, улс төрийн байр суурийг бэхжүүлэн интеграцчилагдах үйл явцад нэгтгэх, олон талын оролцоотой удирдлагын механизмаар олон улсын үйл явдлыг зохицуулах явдал гэж үзээд үүндээ стратегийн түнш нэрийн дор өөрийн холбоотнуудаа нэгтгэх геополитикийн далд бодлого явагдаж байна. Энэ нь нөгөө л теллуорократын бодлого буюу уламжлалт евразийн үзэл санаанаас улбаатай. Олон улсын харилцааны нөлөө бүхий төвүүдийн нэг байх гэсэн байр сууриа хадгалах, их гүрний статусаа сэргээх, евразийн нутаг дэвсгэрт нөлөөгөө хадгалахыг чухалчилж байна. Үүнийгээ ч үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа тодорхой тусгажээ.

ОХУ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа эдийн засгийн салбар дахь Оросын үндэсний ашиг сонирхлыг тэргүүлэх чиглэл¹ гэж заасан байна. ОХУ-ын дипломат бодлогын хамгийн гол зорилт нь эдийн засгийн бие даасан байдлыг бүрдүүлэх явдал юм. Эдийн засгийн хүчтэй байдал өнөөгийн олон улсын харилцааны тэмцлийн чухал хөшүүрэг болжээ. Тиймээс ОХУ-ын өмнө хуучин ЗХУ-ын үеийн дэд бүтцэд тулгуурлан томоохон хотуудыг холбосон эдийн засгийн интеграцчилалыг хөгжүүлж, эдийн засгийн томоохон төвүүдийг бий болгох, хамтын замаар асуудлыг шийдвэрлэх механизмыг бүрдүүлэх асуудал туйлын чухлаар тавигдаж байна. 2002 оны 6 сард Канадад болсон “Их найм”-ын

уулзалтаар Оросыг зах зээлийн эдийн засагтай орон гэдгийг албан ёсоор зарлав. ОХУ байгалийн асар их нөөцтэй орон. Энэ нь эдийн засгийн өндөр хөгжилтэй, түүхий эдийн гачигдалд орсон, технологийн их гүрнүүдийн анхаарлыг зүй ёсоор татаж байна. Сибирь, Алс Дорнод зэрэг асар удам нутгийн байгалийн нөөц баялгийг ашиглах, гадаадын техник технологи, хөрөнгө оруулалтын бодлогыг зөв явуулахаас Оросын эдийн засгийн бие даасан байдал ихээхэн шалтгаална. Тиймээс Оросын дотоод улс төр, эдийн засгийн гол зорилт нь улс төрийн хувьд Москвагаас хамааралтай эдийн засгийн хувьд бүрэн бие даасан төвүүдийг бий болгох явдал гэж Оросын эдийн засагчид, улс төрчид үзэж байна. Энэ нь хоёр талтай юм. Учир нь өнөөгийн олон улсын харилцаанд эдийн засгийн томоохон бүсүүдийн гүйцэтгэх үүрэг ихээхэн өсч байгаатай холбоотой. Эдийн засгийн томоохон бүсийг байгуулснаар хямралаас гарах төдийгүй хамтын замаар асуудлыг шийдвэрлэх бүс нутгийн хэмжээний олон улсын байгууллагын үүргийг гүйцэтгэх боломжтой болно. Энэ нь улс төр, эдийн засгийн хувьд аль аль талдаа ашигтай юм. Нөгөөтэйгүүр, эдийн засгийн хувьд хүчтэй болсноор хуучин өөрийн нөлөөнд байсан улс орнууддаа улс төрийн дэмжлэг, эдийн засгийн тусламж үзүүлэх, нөлөөндөө оруулах замаар евразийн их гүрний бодлогоо явуулах боломжтой. Түүнчлэн бүс нутаг төдийгүй, хил залгаа орших улс орнуудын энх тайван, тогтвортой байдал Оросод туйлын чухал байна. Олон янзын иргэншил, соёл, улс орон ард түмнүүдээс бүрдсэн евразийн өргөн орон зайд орших Оросын газар зүйн байршил, нүсэр том газар нутаг, түүнээс үүссэн хүчний таталцал түлхэлцэл, үүсээд буй геополитикийн нөхцөл байдал маш олон асуудлыг бий болгож байна. Гэхдээ гадаад аюулаас илүү дотоод байдал нь үндэсний аюулгүй байдалд хохирол учруулах хэмжээнд хүрлээ гэдгийг албан ёсны баримт бичгүүдэд, төрийн дээд хэмжээнд ч хүлээн зөвшөөрч байна. Энэ нь улсын дотоод эдийн засаг, нийгэм, улс төр үзэл суртлын хувьд тогтворгүй байгаатай холбоотой. Аливаа улсын гадаад, дотоод аюулгүй байдал бүрэн хангагдсан тэр л нөхцөлд тогтвортой байдал бий болдог. Тиймээс ОХУ-ын дотоод байдал тодорхой хэмжээгээр Зөвлөлтийн дараах орон зай, цаашлаад дэлхийн тавцан дээрх Оросын жин нөлөөг тодорхойлох гол хүчин зүйл болж өгөх юм.

Сүүлийн 10 жилийн хугацаанд ОХУ олон улсын хамтын ажиллагаанд нилээд идэвхитэй оролцож олон улсын нөлөө бүхий байгууллага, институтэд гишүүнээр элсэв. Гол зорилго нь дэлхийн тавцанд Оросын байр суурийг бэхжүүлэх явдал юм. “Их найм”-ын уулзалтаар Оросыг албан ёсны гишүүнээр элсүүлж 2006 онд болох “Их найм”-ын уулзалтыг Москвад хийхээр тохиролцсон нь нэг том амжилт юм. ОХУ бие даасан прагматик гадаад бодлого явуулахдаа

дэс дараалсан, урьдчилан сэргийлсэн, харилцан ашигтай прагматик бодлогод тулгуурлах болно² гэдгээ гадаад бодлогын үзэл баримтлалдаа онцлон заажээ. Мөн тэнд гадаад бодлогын ирээдүйн зорилт, түүнд хүрэх боломжит арга зам хоёрын дунд ухаалаг тэнцвэржилт барихыг³ чухалчлан заажээ. Энэ нь бүхий л чиглэлээр томоохон бодлого явуулдаг евразийн гүрэн Оросын геополитикийн байршлаар нөхцөлджээ. Өөрөөр хэлбэл, өрнөдийн орнууд, АНУ, Ази-Номхон далайн бүс нутгийн улс орнуудтай эн тэнцүү хэмжээнд харилцана гэж үзэж байна. ОХУ дэлхийд ганц туйлт ертөнц тогтоохын эсрэг байр сууринд хатуу зогсож тэгш эрх, харилцан хүндэтгэл, харилцан ашигтай хамтын ажиллагааны зарчимд тулгуурласан “олон туйлт ертөнцийн” тухай үзэл санааг илэрхийлж, олон улсын харилцааны тогтвортой системийг бий болгох сонирхолтой гэдгээ ч мөн гадаад бодлогын үзэл баримтлалдаа илэрхийлжээ. Гадаад бодлогын чиглэлдээ ТУХН-ийн улс орнуудад ихээхэн анхаарчээ. ТУХН бол Оросын нөлөөллийн хүрээний хамгийн сүүлчийн бүс, их гүрний байр сууриа хадгалж байх хамгийн чухал бааз газар нь бөгөөд ТУХН-ийн орнуудад явуулах дипломат бодлогын хамгийн гол цөм нь үүнд оршиж байгаа юм. Орос улс дипломат бодлогоо юуны түрүүнд АНУ руу чиглүүлж, хамтран ажиллахын зэрэгцээ эсэргүүцэх замаар Америкийг хазаарлах бодлого явуулж байна. Орос улс дэлхийн, түүнчлэн олон улсын хэрэг явдал, түүний дотор Орос-Америкийн харилцааны бүх салбарт Америкт хавчигдсан идэвхигүй байдалтай явж ирсэн. АНУ Оросыг дахин толгойгоо өндийлгөн Америктай сөргөлдөхүйц хүчин болохоос сэрэмжлэн, стратегийн дарамт шахалт үзүүлэхийг чармайсаар ирсэн билээ.

2001 оны 9-р сарын 11-нд АНУ-д болсон террорист халдлага нь барууны орнуудын Орост хандах хандлагыг эрс өөрчилсөн юм. Учир нь энэ халдлага глобал хэмжээний томоохон аюул байгааг харуулж Оростой ялангуяа аюулгүй байдлын салбарт хамтран ажиллахад хүргэсэн юм.

Орос-Америкийн харилцаан дахь өөр нэг томоохон асуудал нь пуужингийн хамгаалалтын эсрэг системийг бий болгох явдал. 1972 оны гэрээг хэрэв цуцлах аваас цөмийн зэвсгийг хязгаарлах, хорогдуулах дэглэм бүхэлдээ өөрчлөгдөж Орос, Америкийн хоёр талын харилцаа хурцдах аюултай гэж үздэг. Хэдийгээр энэ нь зөвхөн Орос-АНУ-ын хооронд байгуулсан гэрээ боловч зөвхөн энэ хоёр орны шийдвэрлэх асуудал ч бус харин дэлхийн бусад орнуудад ч хамаатай юм. ОХУ хүйтэн дайн дуусч хоёр туйлт систем задран унаж өнөөгийн олон улсын нөхцөл байдал эрс өөр болсонтой холбогдуулан 1972 оны гэрээг шинэчлэн боловсруулж, өнөөгийн байдалд тохирсон, аюулгүй байдлын шинэ нөхцлийг хангасан гэрээ болгон өөрчлөх хэрэгтэй гэсэн байр суурь

баримталдаг. ОХУ-ын энэ байр суурь нь АНУ цөмийн пуужингийн хөтөлбөрөө хэрэгжүүлсэн ч гэсэн түүнтэй барьцан өөрийн зэвсэглэлийг хөгжүүлж улмаар хоёр улсын хооронд үл итгэлцэх байдал үүсгэхгүй байгааг алхамыг хийсэн. Хоёрдугаарт, Орос уг гэрээнээс гараагүй нь дэлхийн бусад орнуудыг зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг тодорхой хэмжээгээр сааруулсан төдийгүй дэлхийн тогтвортой аюулгүй байдлыг хамгаалж, хүчний тэнцвэртэй байдлыг хангах чухал нөхцөл нь болсон зэргээс үзвэл Орос АНУ-тай аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах бодлого явуулж байна гэж үзэж болно. АНУ пуужингийн довтолгооноос хамгаалах үндэсний систем боловсруулснаар дэлхийд ноёрхлоо улам бэхжүүлэх зорилготой гэж үзээд ОХУ Европын Холбоотой хамтран хамтын аюулгүй байдлыг хангах стратегийн бус пуужингийн довтолгооноос хамгаалах систем бий болгох санал дэвшүүлсэн.⁴ Орос, Америкийн харилцааны үндэс хоёр өөр геополитикийн ашиг сонирхол бүхий стратегийн байр суурь юм. Тэдний стратегийн харилцааг тодорхойлох хамгийн том хүчин зүйл бол хоёр орны цөмийн зэвсгийн чадавхи юм. Орос, Америкийн түншлэлийн гол үндэс нь олон улсын харилцааны тогтвортой аюулгүйн системийг бий болгох сонирхол аль алинд нь байгаа төдийгүй бүс нутгийн мөргөлдөөнийг зохицуулах “орчин үеийн улс төр, цэргийн шинжтэй үйл ажиллагааг зохицуулах хүчний зохицуулалт”-ыг сайжруулах явдлаар нөхцөлдөнө. Америкийн талаар хатуу, прагматик байр суурьтай байж, улс үндэсний эрх ашигт хор хохирол учруулах асуудал дээр бүхий л хүчээр тэмцэх болно. Гэхдээ “бүхий л хүчээ төвлөрүүлж улс орон, эдийн засгаа сэргээж хүн ардаа баян чинээлэг болгох амин чухал үүргээ биелүүлэхийн тулд зэрэгцэн оршиж, хамтран ажиллах болно”⁵ гэсэн зарчимд тулгуурладаг. АНД-н бүс нутагт явуулж буй АНУ-ын гадаад бодлогын гол зорилт нь стратегийн нөлөөллөө хэвээр хадгалах, Орос-Хятадын хэт ойртолтыг сэрэмжлэх, Япон, Өмнөд Солонгостой холбоотны харилцаагаа хөгжүүлэхэд чиглэгдэж байна.

АНУ олон улсын терроризмтай тэмцэхдээ Дундад Азийн баян Узбекистаныг сонгон авч тэнд цэргийн бааз байгуулав. ОХУ, Гүрж улстай харилцаа нь хурцдав. Эл хоёр гүрэн газрын тос, ялангуяа Каспийн сав газрын нефтийн нөөцөд ихээхэн шохоорхож байна. 2002 оны 5 сард болж өнгөрсөн Орос-Америкийн дээд хэмжээний уулзалтаар хоёр тал одоо байгаа 6000-7000 цөмийн зэвсэгт хошууны тоог ирэх 10 жилийн хугацаанд 1700-2200 хүртэл бууруулах гэрээнд гарын үсэг зурсан юм. Зэвсгийг хорогдуулахад зарцуулах 20 миллиард ам.долларыг Оросод өгөх ажээ. Европт явуулах уламжлалт дипломат бодлого нь Оросын дипломат үйл ажиллагааны бас нэгэн гол чиглэл мөн. Хэдэн жилийн туршид Орос нь НАТО-ийн дорно зүгт тэлэх

бодлогыг эсэргүүцэж, Европын аюулгүй байдлын шинэ механизмыг бий болгоход чиглэсэн үйл ажиллагаагаа идэвхижүүлэх замаар баруунд эсэргүүцэл үзүүлснээр барууны тэлэн өргөтгөх стратеги бодлогод саад учруулж, Европ дахь Оросын ашиг сонирхлыг зохих хэмжээгээр хадгалж чаджээ. Баруун Европын улс орнууд ялангуяа Герман зэрэг улсын хөрөнгө оруулалт, зээл тусламж эдүгээ тус орны гадаад худалдаа, эдийн засагт тоймтой байр суурь эзэлдэг нь үүнийг гэрчилнэ. 2002 оны 6 сард Ромд болсон ОХУ-НАТО-ийн дээд хэмжээний уулзалтаар Орос-НАТО-ийн зөвлөл байгуулж, ойрын саруудад хэрэгжүүлэх хамтын ажиллагааныхаа хөтөлбөрийг зөвшилцөж, улмаар Европ – Атлантын бүсийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой төсөл хэрэгжүүлэхээр болсон. Харин ОХУ-ын Коммунист намын дарга тэргүүтэй зарим хүмүүс Орос-НАТО-ийн шинэ харилцааг төдийлөн дэмжихгүй байна. “Новая газета” сонинд “ОХУ-НАТО-ийн шинэ харилцааны дүнд нэгдүгээрт, олон нийтийн ашиг сонирхлыг татаж байгаа тэр салбарт хамтран ажиллах боломж нээгдлээ. Хоёрдугаарт, терроризм, үй олноор устгах зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх, онц ноцтой байдлыг сулруулах зэрэг асуудлуудаар хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ” хэмээжээ. Юутай ч Орос-НАТО-ийн харилцааны шинэ хэлбэр нь нэн тэргүүнд олон улсын алан хядлагатай тэмцэхэд нааштай нөлөө үзүүлнэ гэж найдаж байгаа юм.

Ази, Номхон далайн чиглэлээр явуулах дипломат бодлогодоо ч ихээхэн ач холбогдол өгч байна. АНД-н дипломат бодлогын хүрээнд Хятадад явуулж буй үйл ажиллагаа нь харьцангуй урагштай байна. Гадаад бодлогодоо зохицуулалт хийж өөрийн өвөрмөц онцлогтой соёлын уламжлал, нутаг дэвсгэрийн байршил, үндэсний эрх ашигт нийцсэн бодлого явуулах болсноор энэ нь Оросыг бүх талын тэнцвэртэй дипломат бодлого явуулахад түлхэц болж, Б.Елцины өрнөдийг хэт ихээр түших, тэдэнд найдах бодлогоос их гүрний бие даасан бодлогод шилжих нэг нөхцөл болж өгчээ. Оросын геополитикийн орчин, стратегийн ашиг сонирхол, бие даасан өрнө, дорнийн аль аль хүчин зүйлүүдийг харгалзсан гадаад бодлого баримтлахыг шаардаж байна. Оросын их гүрний гадаад бодлого хуучин их гүрний мөрөөдлөөс харьцангуй бодит байдалд шилжив. Өөрөөр хэлбэл, үзэл сурталжсан бодлогоос геополитикийн прагматик дипломат бодлогод шилжин орлоо гэж судлаачид үзэж байна. Орос үндэсний ашиг сонирхол, гадаад бодлогын зорилтыг тэнцвэржүүлэх зарчмыг баримтлах болов.

Орос өргөн уудам нутагтай, байгалийн арвин их баялагтай, шинжлэх ухаан-техникийн чадавхи өндөр, цөмийн зэвсгийн асар их потенциалтай улс бөгөөд НҮБ-ийн Аюулгүйн Зөвлөлийн Байнгын гишүүн зэрэг гадаад бодлогын нэн чухал эх сурвалжаа алдаагүй байна. Иймд Орос нь дэлхийн их гүрэн хэвээр байгаа төдийгүй дэлхийн тавцанд

түүний дотор Ази Номхон далайн бүсэд түүний гүйцэтгэх үүрэг ч цаашид нэмэгдэх магадлалтай юм. ОХУ Европ, Азийн аль алины хүчин зүйлийг харгалзан өнөө үеийн олон улсын харилцааны онцлогтой уялдуулсан гадаад бодлогыг явуулснаар тодорхой хэмжээгээр амжилтанд хүрч байгаа билээ.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Концепция национальной безопасности РФ. 2001
2. Концепция внешней политики РФ. 2001
3. Мөн тэнд
4. www.armcontrol.com
5. Дугин А. “Основы геополитики. Геополитическое будущее России” М.,1997.стр369